

Хотын Худалдааны байгууллагын үүсэл

1921-11-5-анд монгол улс анх ЗХУ-тай худалдааны харилцаа тогтоосон юм. 1965 онд Гадаад яамны ёслолын хэлтсээс гаргасан жагсаалтаас 1929 онд хоршооны ерөнхий хорооны Улаанбаатар хотын хэлтэс бий болж дараа 1931-7-1-энд Намын Төв хорооны шийдвэрээр Улаанбаатар хотын хоршоог байгуулжээ.

Хотын худалдааны газар биеэ дааж гарсан явдал нийслэлийн дотор худалдааг өргөжүүлэн нийслэлийн хүн ардыг бараа, хүнсний зүйлээр хангахад чухал ач холбогдолтой болсон юм.

1932 онд нийслэл хотын хоршоо төв дэлгүүр 1, дэлгүүр 7, жижиг мухлаг 11, махны дэлгүүр 16, нефтийн дэлгүүр 1, бүгд 36 дэлгүүртэй байсан бол 1939 онд дэлгүүр 118, жижиг салбар 87 тойг болжээ.

Зөвхөн 1932 онд нийслэл хотын хоршооны байгууллага хотын ард түмэнд 15530120 төгрөгийн бараа борлуулжээ.

1931 оны сүүл, 1932 оны эхээр нийслэл хотод энгийн худалдааны хятад пүүс дэлгүүр 211, төвд 7, орос 2, монгол 87, байсан бөгөөд бүрэн бус мэдээгээр нэгдэн ажиллаж байгаа хүмүүс 425 байжээ.

1925-1927- онд нийслэл хотод ажиллаж байсан энгийн худалдааны пүүс, дэлгүүрүүд

	1925 он	1927 он
Монголчууд	32	59
Орос	21	10
Хятад	175	231
Төвд		7
бусад		18
	1925 он	1927 он
Хятадын нээлттэй дэлгүүр	110	112
Бүгд	330	428 тус тус байжээ.

1931-5-9-энд Эрхлэх товчооны 23 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлээр Төв коперативаас хотын хэлтсийг тусгаарлаж Улаанбаатар хотын коператив болгох ажлыг

1931-7-1-нээс гүйцэтгэж түүнд Засгийн газраас 600000, төв коперативаас 600000 төгрөгийн үндсэн хөрөнгийг хүүгүйгээр зээл олгож, төв коперативаас хотын хэлтсийг тусгаарлаж, хотын коператив байгуулах, зохион байгуулах товчоог байгуулсан байна

1932-1-1-энд архины онц эрхийг хадгалах газрыг татан буулгасан. Улаанбаатарын Архи, пивоны завод, архи агуулах газруудыг худалдаа үйлдвэрийн яаманд шилжүүлсэн.

1940-6-14-өд авто конторыг татан буулгаж, хөрөнгийг албан захиалгын газар шилжүүлжээ.

1940-7-19-энд Сайд нарын Зөвлөлийн 24 дүгээр хурлын 4 дүгээр зүйлээр зах зээлийн газар хувийн худалдаа хийгчдээс нэг удаагийн татвар хураах журам тогтоож, хот, аймгийн төв 1940-8-15-нас эхлэн явуулах.

1940-9-1-нээс Улаанбаатар хотод тусгай комиссын худалдааны дэлгүүр нээхээр тогтоожээ.

1942-1-27-онд Сайд нарын Зөвлөлийн 4 дүгээр хурлын 3 дугаар зүйлээр Улаанбаатар хотын худалдааны Триест дүрмийг батлаад, Триестийн даргаар Чойдоржийг томилж, Триестийн орон тоо, төсвийг баталж өгөхийг сангийн яаманд даалгасан байна.

1942-7-4-нд Сайд нарын Зөвлөлийн 25 дугаар хурлын 2 дугаар зүйлээр хотын

худалдааны Триестийн 1942 оны бараа гүйлгээний төлөвлөгөөг 62,000,000 төгрөгөөр баталжээ.

1952-4-12-нд Улаанбаатар хотын төв бараа бааз, түүхий эдийн баазыг 1952-1-1-нээс гадаад худалдааны газар шилжүүлжээ.

Худалдааны яаманд хотын худалдааны Триестийн бараа баазыг 1952-4-16-нас татан буулгаж, дэлгүүрийг Гадаад худалдааны газар шилжүүлсэн байна.

1953-4-12-нд Сайд нарын Зөвлөл, Намын Төв Хорооны 124/38 дугаар тогтоолоор хотын худалдааны Триестийн бараа баазыг 1952-4-15-нас татан буулгаж дэлгүүрүүдийг Гадаад худалдааны газрын харьяанд шилжүүлжээ.

1957-1-22-нд Худалдааны яамны харьяа нийтийн хоолны Триестийг 1954-1-1-нээс татан буулгаж, гуанз, ресторануудыг бүх зүйлийн хамт хотын худалдааны Триестэд шилжүүлжээ.

1954-9-6-нд Аймаг хотуудын АДХ-ын гүйцэтгэх захиргаанд 1955-1-1-нээс эхлэн худалдааны хэлтэс байгуулсан байна.

1956-6-8-нд Улаанбаатар хотын захиргааны худалдааны хэлтсийг татан буулгаад хотын төлөвлөгөөний комисст худалдааны байцаагчийн орон тоог бий болгожээ.

1956-6-1-нд Сайд нарын Зөвлөлийн 271 дүгээр тогтоолоор тус улсын гаалийн бүх асуудлыг 1956-7-1-нээс Сангийн яам, цэрэг, нийгмийг аюулаас хамгаалах яамнаас Худалдааны яаманд шилжүүлсэн .

1957-8-10-нд Сайд нарын Зөвлөлийн 256 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын худалдааны трест, нийтийн хоолны трестийг хотын гүйцэтгэх захиргаанд харьяалуулахаар тогтоожээ.

1958-2-8-нд сайд нарын Зөвлөлийн 24 дүгээр тогтоолоор Улаанбаатар хотын бэлтгэл конторыг 1958-3-1-нээс аж ахуйн тооцоонд оруулж хотын гүйцэтгэх захиргаанд харьяалуулжээ.

1958-9-5-нд Сайд нарын Зөвлөл, Намын Төв хорооны 290/274 дүгээр тогтоолоор Улаанбаатар р хотын худалдааны Триестийн бааз дээр

- Үйлдвэрийн барааны худалдааны Триест

- Хүнсний барааны худалдааны Триест

- Мах, сүү, ногооны худалдааны Триестийг тус тус аж ахуйн тооцоон дээр

1958-9-15-наас байгуулахаар тогтоожээ.

1958-12-10-анд сайд нарын Зөвлөлийн 380 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын аж үйлдвэрийн барааны Триест, хүнсний барааны Триест, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний Триест, нийтийн хоолны Триест их дэлгүүр, бэлтгэл конторыг худалдааны бэлтгэлийн яаманд харьяалуулжээ.

1960-3-17-онд Сайд нарын Зөвлөлийн 101 дүгээр тогтоолоор Налайхын үйлдвэрийн ажилчдын хэрэгцээний хэлтсийг худалдааны Триест болгон байгуулж, Улаанбаатар хотын захиргаанд харьяалуулжээ.

1960-11-3-нд Сайд нарын Зөвлөлийн 484 дүгээр тогтоолоор Улаанбаатар хотын худалдаа, нийтийн хоол, номын худалдаа, төмөр замын худалдааны байгууллагуудад хөдөлмөр, цалин хөлсний шинэ системийг 1960 оны 11 дүгээр сараас нэвтрүүлэхээр тогтоожээ.

1961-8-22-онд Намын Төв Хороо, Сайд нарын Зөвлөлийн 290/443 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын захиргааны худалдааны хэлтсийг татан буулгаж, түүний оронд өөрийн шууд харьяанд аж ахуйн тооцоон дээр ажиллах Улаанбаатар хотын худалдааг удирдах газрыг 1961-9-1-нээс байгуулахаар тогтоожээ.

1961-8-23-анд Намын Төв Хороо, Сайд нарын Зөвлөлийн 290/443 дугаар тогтоолоор Хотын худалдааны зохион байгуулалтад 1961-9-1-нээс дор дурдсан өөрчлөлт оруулжээ.

Худалдаа бэлтгэлийн яамны харьяа улсын их дэлгүүрийг хотын захиргааны харьяанд

-Мах сүү, ногооны Триестийг татан буулгаж, түүний харьяа, жижиглэн худалдаалах цэгүүдийг хүнсний барааны Триестэд

-Мах сүү, ногооны Триестийн хүнсний ногооны баазыг өргөтгөн хөдөөд аж ахуйн бүтээгдэхүүн, бэлтгэх бааз болгон өөрчилж, хотын худалдаа удирдах газарт шууд харьяалуулахаар тус тус тогтоожээ.

1961-11-15-анд Сайд нарын Зөвлөлийн 581 дүгээр тогтоолоор Улаанбаатар хотын хүнсний барааны Триест, аж үйлдвэрийн барааны Триест, нийтийн хоолны Триестийг тус тус 1961 оны 12 дугаар сарын 1-нэр татан буулгахаар тогтоожээ. Удирдлагыг худалдаа удирдах газарт төвлөрүүлжээ.

1960-12-9-энд Сайд нарын Зөвлөлийн 417 дугаар тогтоолоор хотын худалдаа удирдах газрын авто тээврийн баазыг 1967-1-1-нээс тээвэр, түлш, хангамжийн нэгдсэн бааз болгон өргөтгөхөөр тогтоожээ.

1967-5-24-энд Сайд нарын Зөвлөлийн 155 дугаар тогтоолоор Монголын эд хэрэглэгчдийн нийгэмлэгийн төв зөвлөлийн харьяанд ажиллаж байсан худалдааны ажилчдын соёлын ор-донг Улаанбаатар хотын худалдаа удирдах газарт харьяалуулсан байна.

1968-2-2-нд Сайд нарын Зөвлөлийн 37 дугаар тогтоолоор Хотын худалдааны дэлгүүрийн нэгдсэн 19 захиргааг 1968-3-1-нээс эхлэн худалдааны 7 дугаар контор болгож, аж ахуйн тооцооны үндсэн дээр ажиллуулахаар тогтоожээ.

1969-12-19-нд Сайд нарын Зөвлөлийн 426 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын худалдаа удирдах газрын төхөөрөмж, рекламн конторыг худалдаа бэлтгэлийн яаманд шууд харьяалуулан, худалдааны төхөөрөмжийн засвар, зарлал, чимэглэлийн газар болгон өргөтгөж, аж ахуйн тооцоон дээр ажиллуулжээ.

1972-4-7-онд Сайд нарын Зөвлөлийн 123 дугаар тогтоолоор хотын худалдаа удирдах газраас нийтийн хоолны ажлыг салгаж, Улаанбаатар хотын нийтийн хоолны удирдах газрыг аж ахуйн тооцооны үндсэн дээр тусгаарлан байгуулахаар тогтоожээ.

1972-10-27-онд Сайд нарын Зөвлөлийн 421 дүгээр тогтоолоор хотын худалдаа удирдах газрын харьяанд худалдааны контор 2-ыг нэмж байгуулахаар тогтоожээ.

1973-2-15-нд сайд нарын Зөвлөлийн 34 дүгээр тогтоолоор хотын худалдааны бараа баазыг өөрчлөн уг баазыг нийслэлийн худалдаа, нийтийн хоолны байгууллагын материал, төхөөрөмжийг ханган нийлүүлэх болон барааг жижиглэн савлах, цэг салбарт түгээн хүргэх үүрэг бүхий бааз болгожээ.

1977-1-18-нд Сайд нарын Зөвлөлийн 294 дүгээр тогтоолоор ЗХУ болон ЭЗХТЗ-ийн гишүүн бусад орнуудын буцалгүй тусламжтайгаар Улаанбаатар хотод барьсан хүнсний барааны өөртөө үйлчлэх их дэлгүүр /универсал/-ий ажил үйлчилгээний онцлохыг харгалзан Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргаанд харьяалуулж, аж ахуйн тооцооны үндсэн дээр ажиллуулахаар тогтоожээ